

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2016-2017 ОНЫ  
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

**1. Дээд боловсролын сургалтын байгууллага(ангилал, байршил, өмчийн хэлбэр)**

**1.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо.**

2016-2017 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр Монгол Улсад дээд боловсролын 95<sup>1</sup> байгууллага статистикийн мэдээнд хамрагдаж сургалтын үйл ажиллагаа явуулж байна гэсэн мэдээ өгсөн байна(Хүснэгт 1).

Хүснэгт 1. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо

<b>Дээд боловсролын сургалтын байгууллага</b>				
	Бүгд	Төрийн	Төрийн бус	Гадаадын салбар сургууль
<b>2012-2013</b>	<b>99</b>	15	79	5
<b>2013-2014</b>	<b>100</b>	16	79	5
<b>2014-2015</b>	<b>101</b>	16	80	5
<b>2015-2016</b>	<b>100</b>	17	78	5
<b>2016-2017</b>	<b>95</b>	17	74	4

Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 5-аар буюу ойролцоогоор 5.0 хувиар буурсан байна.Энэ нь дараах өөрчлөлтүүдтэй холбоотой юм.

Үүнд:i) Төрийн бус өмчийн сургуулиудын хувьд: Евро-ази, Либерти, Шонхор дээд сургуулиуд, Гэгээ, Их шавь коллежууд нь 2016-2017 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулаагүй, Гүрэн дээд сургууль шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн;

ii) Гадаадын салбар сургуулийн хувьд: Дорнод Казакстаны улсын их сургуулийн Баян-өлгий аймаг дахь салбар сургууль үйл ажиллагаагаа зогсоосон байна.

**1.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал.**

Дээд боловсролын сургалтын 95 байгууллагын 32.6 хувь нь их сургууль, 60.0 хувь нь дээд сургууль, 3.2 хувь нь коллежийн ангилалд багтаж, 4.2 хувь нь гадаадын салбар сургууль байгаа бөгөөд өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад их сургуулийн тоо 6-гаар буюу 24.0 хувиар өсч, дээд сургуулийн тоо 7-оор буюу 10.9 хувиар, коллежийн тоо 3-аар буюу 50.0 хувиар, гадаадын салбар сургуулийн тоо 1-ээр буюу 20.0 хувиар тус тус буурсан байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо(ангиллаар<sup>2</sup>)

<b>Дээд боловсролын сургалтын байгууллага</b>					
	Бүгд	Их сургууль	Дээд сургууль	Коллеж	Гадаадын салбар сургууль
<b>2012-2013</b>	<b>99</b>	17	58	19	5

<sup>1</sup>2016-2017 оны хичээлийн жилд статистикийн мэдээнд хамрагдсан их, дээд сургуулийн тоо

<sup>2</sup>"Боловсролын тухай хууль"-ийн 15-р зүйлд Дээд боловсролын сургалтын байгууллагыг их сургууль, дээд сургууль, коллеж гэсэн ангилалтай байхаар заасан.БСШУ-ны сайдын 2004 оны 140-р тушаалаар Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг, БСШУ-ны сайдын 2004 оны 238-р тушаалаар Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тус тус тогтоосон. БСШУ-ны сайдын 2010 оны 26-р тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам"-ыг мөрдөж байна.

<b>2013-2014</b>	<b>100</b>	18	62	15	5
<b>2014-2015</b>	<b>101</b>	18	70	8	5
<b>2015-2016</b>	<b>100</b>	25	64	6	5
<b>2016-2017</b>	<b>95</b>	31	57	3	4

Дотоодын төрийн өмчийн 17 сургуулийн 13(76.5%) нь их сургуулийн, 3(17.6%) нь дээд сургуулийн, 1(5.9%) нь коллежийн; төрийн бус өмчийн 74 сургуулийн 18(24.3%) нь их сургуулийн, 55(73.0%) нь дээд сургуулийн, 2(2.7%) нь коллежийн ангилалд багтаж сургалтын ажил эрхэлж байна. Үүнийг өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад төрийн бус өмчийн их, дээд сургуулийн ангилалд нилээд өөрчлөлт гарчээ. Энэ нь дээр дурдсан үйл ажиллагаа явуулаагүй дээд сургуулиудаас гадна 5 сургуулийн ангилал өөрчлөгдөж их сургууль болсон. Үүнд: Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Сити дээд сургууль, Сэрүүлэг дээд сургууль, Үндэсний техникийн дээд сургууль, Хүмүүнлэгийн их сургуулийн харьяа Эрдмийн сургууль, Шихихутуг хууль зүйн дээд сургуулиуд нь их сургуулийн статустай болсон, Сэтгүүлч коллеж нь дээд сургуулийн статустай болсонтой тус тус холбоотой.

Сүүлийн 5 жилийн явцад дээд боловсролын сургалтын байгууллагын ангилалд ихээхэн өөрчлөлт гарч, энэ нь төрийн ба төрийн бус өмчийн сургуулиудад адилхан хамаарч байна. Дээрх хугацаанд их сургуулийн тоо 17-оос 31 болтлоо нэмэгдэж, эсрэгээр коллежийн тоо 19-өөс 3 болтлоо буурчээ.

### **1.3. Дээд боловсролын сургалтын байгууллагын байршил.**

Дээд боловсролын сургалтын 95 байгууллагаас 87 нь Улаанбаатар хотод, 8 нь хөдөө орон нутагт байрлаж байгааг өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад Улаанбаатарт байрладаг сургуулиудын тоо 4-өөр, хөдөө орон нутагт байрладаг сургуулиудын 1-ээр тус тус буурсан байна.

Хөдөө орон нутагт сургалтын ажил эрхэлдэг бие даасан 8 сургуулийн нэрийг өмчийн хэлбэрээр ангилан доорх хүснэгтэнд харуулав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Хөдөө орон нутагт байрладаг дээд боловсролын сургалтын байгууллага

<b>Төрийн өмчийн</b>	<b>Төрийн бус өмчийн</b>	<b>Гадаадын салбар</b>
1. Ховд их сургууль (Ховд)	1. Дархан дээд сургууль	
2. Дорнод их сургууль (Дорнод)	(Дархан-Уул)	
3. ХААИС-ийн харьяа Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн (Дархан-Уул)	2. Маргад дээд сургууль (Орхон)	
	3. Гурван тамир коллеж (Архангай)	
	4. Далай ван дээд сургууль (Хөвсгөл)	
	5. Худалдааны үндэсний дээд сургууль (Баянхонгор)	

Хөдөө орон нутагт салбартай сургуулиуд авч үзвэл:

төрийн өмчийн сургуулийн хувьд: Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль (3)<sup>3</sup>, Монгол Улсын их сургууль(2), Монгол Улсын Боловсролын их сургууль(1), Соёл, урлагийн их сургууль(1), Ховд их сургууль(1), Шинжлэх ухаан, технологийн их сургууль(2),

<sup>3</sup>Салбар сургуулийн тоог тэмдэглэсэн болно.

төрийн бус өмчийн сургуулийн хувьд: Хүмүүнлэгийн ухааны их сургууль(1), Мандах бүртгэл дээд сургууль(1), Этүгэн их сургууль(2), Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль(1) зэрэг 10 сургууль хөдөө орон нутагт өөрийн салбартай.

## **2.Дээд боловсролын сургалтын байгууллагад Монгол Улсын иргэдээс суралцагчид**

### **2.1. Суралцагчдын тоо**

2016-2017 оны хичээлийн жилийн эхэнд их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 157,138 болж, өмнөх хичээлийн жилээс 5,488-аар буюу 3.4 хувиар буурлаа (Хүснэгт 4). Суралцагчдын тоо төрийн өмчийн сургуульд 3,235-аар буюу 3.4 хувиар, төрийн бус өмчийн сургуульд 2,201-ээр буюу 3.3 хувиар, гадаадын салбар сургуульд 52-оор буюу 16.4 хувиар тус тус буурчээ.

Ийнхүү төрийн ба төрийн бус өмчийн болон гадаадын салбар сургуулиудад суралцагчдын тоо буурсан ч тэдгээрийн нийт дүнд эзлэх хувийн жин өнгөрсөн оны түвшинд байна. Нийт суралцагчдын 91,798 буюу 58.4 хувь нь төрийн өмчийн, 65,075 буюу 41.4 хувь нь төрийн бус өмчийн, 265 буюу 0.2 хувь нь гадаадын салбар сургуульд сурч байна.

Хүснэгт 4. Суралцагчдын тоо(сургуулийн өмчийн хэлбэрээр)

<b>Суралцагчид (сургуулийн өмчийн хэлбэрээр)</b>				
	Бүгд	төрийн	төрийн бус	гадаадын салбар сургууль
<b>2012-2013</b>	<b>175,591</b>	105,751	69,353	487
<b>2013-2014</b>	<b>174,045</b>	101,855	71,689	531
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	103,650	74,233	412
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	95,033	67,276	317
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	91,798	65,075	265

Нийт суралцагчдын 84.5 хувь нь их сургуульд, 15.1 хувь нь дээд сургуульд, 0.3 хувь нь коллежид, 0.2 хувь нь гадаадын салбар сургуульд суралцаж байна (Хүснэгт 5). Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад их сургуульд суралцагчдын эзлэх хувь 9.0 пунктээр өссөн бол, дээд сургуульд суралцагчдын эзлэх хувь 8.8 пунктээр, коллежид суралцагчдын тоо 0.1 пунктээр тус тус бууран, гадаадын салбар сургуулиудад суралцагчдын эзлэх хувь хэвээрээ байна. Энэ нь их сургууль, дээд сургуулийн тооны өөрчлөлт, тухайлбал нилээд хэдэн дээд сургууль их сургуулийн ангилалд шилжсэнтэй холбоотой.

Хүснэгт 5. Суралцагчдын тоо (сургуулийн ангиллаар)

<b>Суралцагчид (сургуулийн ангилалаар)</b>					
	Бүгд	Их сургууль	Дээд сургууль	Коллеж	Гадаадын салбар сургууль
<b>2012-2013</b>	<b>175,591</b>	129,146	41,728	4,230	487
<b>2013-2014</b>	<b>174,075</b>	125,902	44,445	3,198	531
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	128,661	48,515	707	412
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	122,870	38,869	570	317
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	133,187	23,293	393	265

Тооны хувьд их сургуульд суралцагчид 10,317-аар өсч нийт суралцагчдын дүнд эзлэх хувь өмнөх жилийн үзүүлэлтээс 9.2 пунктээр өссөн бол, дээд сургуульд суралцагчид 15,576-аар буурч нийт суралцагчдын дүнд эзлэх хувь өмнөх жилийн үзүүлэлтээс 9.1 пунктээр, коллежид суралцагчид 177 буурч нийт суралцагчдын дүнд эзлэх хувь өмнөх жилийн үзүүлэлтээс 0.1 пунктээр, гадаадын салбар сургуульд суралцагчид 52-аар буурч нийт

суралцагчдын дүнд эзлэх хувь өмнөх жилийн үзүүлэлтээс 0.03 пунктээр тус тус буурсан байна.

Их сургуулиудын хувьд суралцагчдын тоо төрийн өмчийн их сургуульд 2,758-аар буурч, төрийн бус өмчийн их сургуульд 13,075-аар нэмэгдсэн бол дээд сургуульд суралцагчдын тоо төрийн өмчийн сургуульд 413-аар, төрийн бус өмчийн сургуульд 15,163-аар тус тус буурчээ.

#### Хүснэгт 6. Суралцагчдын тоо (өмчийн хэлбэр, сургуулийн ангиллаар)

Ангилал	Нийт	Үүнээс:		Нийт нэгжид эзлэх хувь
		төрийн	төрийн бус	
<b>Бүгд</b>	<b>157,138</b>	<b>91,798</b>	<b>65,340<sup>4</sup></b>	<b>100,0</b>
Их сургууль	132,794	89,787	43,400	84.8
Дээд сургууль	23,686	1,798	21,495	14.8
Коллеж	393	213	180	0.3
Гадаадын салбар сургууль	265	-	265	0.2

Нийт суралцагчдын 143,684 буюу 91.4 хувь нь Улаанбаатар хотод, 13,454 буюу 8.6 хувь нь хөдөө орон нутгийн сургуулиудад (**салбар сургуулиуд ороод**) суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад нийслэл хотод суралцагчдын тоо 4,393-аар, хөдөө орон нутгийн сургуулиудад суралцагчдын тоо 1,095-аар тус тус буурсан бөгөөд тэдгээрийн нийт дүнд эзлэх хувь өнгөрсөн оны түвшинтэй харьцуулбал нийт сурагчдын дүнд нийслэл хотод суралцагчдын эзлэх хувь өмнөх оноос 0.5 пунктээр өссөн бол, хөдөө орон нутгийнх эсрэгээрээ 0.5 пунктээр буурсан байна.

#### Хүснэгт 7. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо (сургуулийн өмчийн хэлбэрээр, ангиллаар, сүүлийн 4 хичээлийн жилээр)

Суралцагчдын тоо	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
<b>Бүгд</b>	<b>174,045</b>	<b>178,295</b>	<b>162,626</b>	<b>157,138</b>
<b>Бүгдээс: Төрийн өмчийн сургуульд</b>	<b>101,855</b>	<b>103,650</b>	<b>95,033</b>	<b>91,798</b>
Төрийн бус өмчийн сургуульд	71,689	74,233	67,276	65,340 <sup>5</sup>
<b>Бүгдээс: Их сургуульд</b>	<b>125,902</b>	<b>128,661</b>	<b>122,870</b>	<b>133,187</b>
Дээд сургуульд	44,445	48,515	38,869	23,293
Коллежид	3,197	707	570	393
Гадаадын салбар сургуульд	531	412	317	265

Хүснэгт 7 дээрх тоон үзүүлэлтээс харахад сүүлийн 4 хичээлийн жилийн эхний 3 жилд нийт суралцагчдын тоо 174 мянгаас 178 мянгын хооронд хэлбэлзэж байсан бол 2015 онд ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсөгчдийн тоо өмнөх жилүүдээс бараг хоёр дахин багассанаас хамаарч 162 мянга болж огцом буурсан байна. Энэ хугацаанд коллежийн тоо цөөрсөн учраас тэдгээрт суралцагчдын тоо 4,230-аас 393 болж тогтмол буурсны дээр гадаадын салбар сургуульд Монгол Улсын иргэдээс суралцагчдын тоо мөн буурах шинжтэй байна.

## 2.2. Суралцагчдын сургалтын хэлбэр ба боловсролын зэрэг

<sup>4</sup>Төрийн бус өмчийн сургуулийн тоонд гадаад салбар сургуулийн тоог оруулсан болно.

<sup>5</sup>Төрийн бус өмчийн сургуулийн тоонд гадаад салбар сургуулийн тоог оруулсан болно.

Энэ хичээлийн жилд 95 их, дээд сургууль нь өдөр<sup>6</sup>, орой, эчнээ хэлбэрээр сургалт явуулж байна.

Хүснэгт 8. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид  
(сургалтын хэлбэрээр)

<b>Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид</b>				
	Бүгд	өдөр	орой	эчнээ
<b>2012-2013</b>	<b>175,591</b>	158,194	4,598	12,799
<b>2013-2014</b>	<b>174,075</b>	156,946	4,364	12,765
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	159,368	4,669	14,258
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	143,775	4,548	14,303
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	138,962	4,254	13,922

2016-2017 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 88.4 хувь нь өдрөөр, 2.7 хувь нь оройгоор, 8.9 хувь нь эчнээ<sup>7</sup>-гээр тус тус сурч байгаа нь өмнөх хичээлийн жилийнхтэй өдрөөр суралцагч хэвээр, оройгоор суралцагч 0.1 пунктээр буурсан бол, эчнээгээр суралцагч 0.1 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Тоогоор нь авч үзвэл нийт суралцагчид 5,488-аар, үүнээс өдрөөр суралцагчид 4,813-аар, оройгоор суралцагчид 294-өөр, эчнээгээр суралцагчид 381-ээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. (Хүснэгт 8).

Хүснэгт 9. Суралцагчдын тоо (боловсролын зэргээр)

<b>Суралцагчид (боловсролын зэргээр)</b>					
	Бүгд	Дипломын дээд	Бакалавр	Магистр	Доктор
<b>2012-2013</b>	<b>175,591</b>	-	155,801	16,630	3,160
<b>2013-2014</b>	<b>174,075</b>	-	152,708	18,063	3,304
<b>2014-2015</b>	<b>178,295</b>	-	155,839	19,065	3,391
<b>2015-2016</b>	<b>162,626</b>	-	140,296	19,005	3,325
<b>2016-2017</b>	<b>157,138</b>	-	133,223	20,066	3,849

2016-2017 оны хичээлийн жилд нийт суралцагчдын тоо 5,488-аар буурсан бөгөөд бакалавр<sup>8</sup>-ын зэргээр суралцагчид 7,073-аар буурч, магистрантурт суралцагчдын тоо 1,061-ээр, докторантурт суралцагчдын тоо 524-өөр тус тус нэмэгдсэн байна. Дээрх бууралт нь үндсэндээ бакалавр (-7,073), тэр тусмаа сургалтын хэлбэрээр нь авч үзвэл бакалаврын өдрийн анги (-6,083) дээр гарчээ. Энэхүү бууралт нь дээд сургуулийн тоо буурсантай холбоотой юм.

Хүснэгт 10. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид  
(боловсролын зэрэг, сургалтын хэлбэрээр)

<b>2015-2016</b>	<b>2016-2017</b>
------------------	------------------

<sup>6</sup> Дээд боловсролын тухай хууль"-ийн 8.1-д "Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалт нь өдөр, орой, эчнээ болон экстернат хэлбэртэй байж болно" гэж заасан.

<sup>7</sup> Эчнээ хөтөлбөрт экстернат орсон болно.

<sup>8</sup> Дээд боловсролын тухай хууль"-ийн 3.3-д "Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалтай байна" гэж заасан. УИХ-аар 2009 онд "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга батлагдаж гарсан, БСШУ-ны сайдын 2010 оны 235-р тушаалаар "Их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн сургуулиудаар бэлтгэж байгаа мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн индекс"-ийг шинэчлэн тогтоосноор дээд боловсролын сургалтын байгууллагуудад дипломын зэргийн сургалтаар элсэлт авахыг 2010-2011 оны хичээлийн жилээс зогсоосон.

	Нийт	өдөр	орой	эчнээ	Нийт	өдөр	орой	эчнээ
<b>Бүгд</b>	<b>162,626</b>	<b>143,775</b>	<b>4,548</b>	<b>14,303</b>	<b>157,138</b>	<b>138,962</b>	<b>4,254</b>	<b>13,922</b>
<b>Хувь, %</b>	<b>100.0</b>	<b>88.4</b>	<b>2.8</b>	<b>8.8</b>	<b>100.0</b>	<b>88.4</b>	<b>2.7</b>	<b>8.9</b>
бакалавр	140,296	125,230	4,463	10,603	133,223	119,147	4,180	9,896
Хувь, %	100.0	89.3	3.2	7.5	100.0	89.4	3.1	7.4
магистр	19,005	15,870	85	3,050	20,066	16,722	74	3,270
Хувь, %	100.0	83.5	0.5	16.0	100.0	83.3	0.4	16.3
доктор	3,325	2,675	0	650	3,849	3,093	-	756
Хувь, %	100.0	80.5	0.0	19.5	100.0	80.4	-	19.6

2016-2017 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 84.8 хувь нь бакалаврын, 12.8 хувь нь магистрын, 2.4 хувь нь докторын зэргийн сургалтанд хамрагдаж байна. Үүнийг өнгөрсөн хичээлийн жилийн хувьтай харьцуулж үзвэл бакалаврын зэргийнх -1.5 пунктээр доошилж, магистрантурынх +1.1, докторантурынх +0.1 пунктээр дээшилжээ. Сүүлийн 2 жилийн байдлаар авч үзвэл бакалаварт суралцагчдын тоо -1.1-ээс -1.5 пунктээр тогтмол буурч байгаа бол магистрантурынх +1-ээс +1.1-ээр, докторантурынх +0.1-ээс +0.4 пунктээр өсч байна.

Бакалавр, магистрантур, докторантурын сургалтын үндсэн хэлбэр нь өдрийн анги бөгөөд бакалаврын зэргээр суралцагчдын 89.4 хувь, магистрантурт суралцагчдын 83.3 хувь, докторантурт суралцагчдын 80.4 хувь нь энэ хэлбэрт хамаарч байна. Энэ нь өмнөх оноос бакалаврт суралцагчид +0.1 пунктээр, магистрантурт суралцагчид -0.2 пунктээр, докторантурт суралцагчид -0.1 пунктээр буурсан байна. Харин оройн ангийн суралцагчдын хувь бакалаврт 3.1, магистрантурт 0.4, докторантурт оройн ангигүй байгаа бол эчнээ ангийн суралцагчдын хувь бакалаврт 7.4, магистрантурт 16.3, докторантурт 19.6 тус тус байна.

### 2.3. Суралцагчдын хүйсийн харьцаа

Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 91,522 буюу 58.2 хувийг эмэгтэй, 41.8 хувийг эрэгтэй суралцагч бүрдүүлж, хүйсийн ялгааны индекс 1.39 байна. Энэ нь өөрөөр хэлбэл 100 эрэгтэй суралцагчид 139 эмэгтэй ногдож байна гэсэн үг бөгөөд дээрх үзүүлэлт өнгөрсөн оны түвшинд байна.

Хүснэгт 11. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид (хүйс, боловсролын зэргээр)

	бакалавр	магистр	доктор
эрэгтэй	42.4%	37.4%	42.3%
эмэгтэй	57.6%	62.6%	57.7%

Боловсролын бүхий л зэргээр суралцагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж байгаагаас магистрантурт суралцагч эмэгтэйчүүдийн эзлэх хувь бакалавр болон докторантурт суралцагчдынхаас арай илүү өндөр байна.

Хүснэгт 12. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын хүйсийн харьцаа (сүүлийн 5 хичээлийн жилээр)

Суралцагчдын тоо	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Бүгд	175,591	174,045	178,295	162,626	157,138
Бүгдээс: -Эмэгтэй	102,427	101,783	102,520	93,674	91,526

-Эрэгтэй	73,164	72,292	75,775	68,952	65,612
- Эмэгтэй, эрэгтэйн харьцаа	1.40	1.41	1.35	1.36	1.39
- Нийт дүнд эмэгтэйчүүд эзлэх хувь /%/	58.3	58.5	57.5	57.6	58.2

Дээд боловсрол эзэмшигчдийн хувьд эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа сүүлийн жилүүдэд нэг түвшинд (1.4) тогтворжих хандлагатай нь сүүлийн 5 жилийн статистикаас харагдаж байна.

## 2.4. Суралцагчдын мэргэжлийн чиглэл<sup>9</sup>

2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн бакалавр, магистрантур, докторантурт шинээр элсэгчдийн мэргэжлийн чиглэл, индексийг тодорхойлохдоо Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 болон А/370 дугаар тушаалуудаар батлагдсан мэргэжлийн /хөтөлбөр/чиглэл, индексийг, 2014-2015 оны хичээлийн жилээс өмнө элсэн суралцаж буй суралцагчдын хувьд тэдгээрийг төгстөл нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай” 2010 оны 235 дугаар тушаалын дагуу тухайн сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн /хөтөлбөр/ чиглэл, индексийг мөрдөхөөр болсон.

Шинэчлэн батлагдсан мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индекст хуучныг дүйцүүлэн багцалж авч үзвэл: нийт суралцагчдын 14.0хувь нь боловсрол; 7.5хувь нь урлаг ба хүмүүнлэг; 5.2 хувь нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй; 26.7хувь нь бизнес, удирдлага, эрх зүй; 3.6хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик; 2.7 хувь нь мэдээлэл, харилцаа холбооны технологи; 17.3хувь нь инженерчилэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт; 2.6хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй; 11.8хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал; 4.0 хувь нь үйлчилгээ; 4.6 хувь нь бусад чиглэл (**дээрх салбаруудад одоогоор хамааруулах боломжгүй**)-ээр тус тус суралцаж байна.

Эдгээр үзүүлэлт нь өмнөх оны түвшингээс боловсролын чиглэлийн эзлэх хувь 0.4, урлаг, хүмүүнлэгийн чиглэлийн эзлэх хувь 0.4 пунктээр тус тус өссөн бол нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлийн эзлэх хувь 1.1, байгалийн шинжлэх ухаан, математик, статистикийн чиглэлийн эзлэх хувь 0.5, инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт 1.7, хөдөө аж ахуй, ой, засагны аж ахуй, мал эмнэл зүй 0.1 пунктээр тус тус буурсан байна. Харин бизнес, удирдлага, эрх зүй, мэдээлэл, харилцаа холбооны технологи, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын чиглэлийн эзлэх хувь өмнөх оны түвшинтэй ижил байна.

Боловсролын олон улсын шинэчилсэн стандарт ангиллаар боловсролын салбарын мэргэжлийн чиглэлийг хуучин 8 бүлэгт хуваан ангилж байсныг илүү нарийвчлан 10 бүлэгтэй болгосон. Тухайлбал хуучнаар Нийгмийн шинжлэх ухааны бүлэгт орж байсан “Бизнес, удирдлага, эрх зүй”-г салгаж тусгай бүлэг болгосны дээр мөн Байгалийн шинжлэх ухааны бүлэгт байсан “Компьютерийн ухаан”-ыг Техник, технологийн бүлэгт байсан “Мэдээлэл, холбооны технологи ба систем”-тэй нийлүүлэн “Мэдээлэл, харилцаа холбооны технологи” гэсэн шинэ бүлэг нэмж гаргасан юм. Иймд өнгөрсөн оноос эхлэн энэ шинэ ангиллын дагуу суралцагчдын мэргэжлийн чиглэлийг ялган гаргаж байгаа билээ. Ингэхэд хуучин ангиллаар гаргасан өмнөх онуудын үзүүлэлтүүдийг шинэ ангилалд шилжүүлэн гаргасан сүүлийн хоёр оны үзүүлэлттэй харьцуулахад бага зэргийн хүндрэлтэй байгаач ангилал дотор нь зарим салбаруудыг шилжүүлэн тооцох замаар жишиж үзэв.

Хүснэгт 13. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын мэргэжлийн чиглэлийн эзлэх хувь (сүүлийн 8 жилээр)

<sup>9</sup>Суралцагчдын мэргэжлийн чиглэлийг тодорхойлохдоо ЮНЕСКО-гоос батлан гаргаж, өөрийн гишүүн орнууддаа зөвлөмж болгосон “Боловсролын олон улсын стандарт ангилал”-ыг (1997 оны болон 2011 онд шинэчлэгдсэн) үндсэндээ баримталж байна.

Мэргэжлийн чиглэл(хөтөлбөр)-ийн нэр	Нийт суралцагчдад тухайн мэргэжлийн чиглэлийн эзлэх хувь (%)							
	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
01.Боловсрол	13.3	13.2	13.0	12.6	12.6	12.7	13.6	14.0
02.Урлаг, хүмүүнлэг	8.6	8.7	8.6	7.6	7.1	7.1	7.1	7.5
03. Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	35.8	34.5	35.3	34.8	34.6	7.0	6.3	5.2
04. Бизнес, удирдлага, эрх зүй	Дээрх “Нийгмийн шинжлэх ухаан” бүлэгт орсон.					26.1	26.7	26.7
05. Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	7.0	7.0	6.9	6.7	6.6	4.6	4.1	3.6
06. Мэдээлэл, харилцаа холбооны технологи	Компьютерийн ухаан нь “Байгалийн шинжлэх ухаан”-д, бусад нь Инженерийн бүлэгт орсон.					2.8	2.7	2.7
07. Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт	17.1	17.6	18.9	19.2	19.5	18.6	19.0	17.3
08. Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	2.8	2.9	3.1	3.5	3.3	2.9	2.7	2.6
09. Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	9.8	10.6	9.2	10.0	11.0	11.6	11.8	11.8
10. Үйлчилгээ	5.6	5.5	5.1	5.5	5.4	4.0	4.0	4.0
11. Бусад	Энэ онуудын “Бусад” нь “Үйлчилгээ” бүлэгт орсон.					2.6	1.9	4.6
<b>Нийт дүн</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>

Сүүлийн 8 жилийн статистикийн мэдээнээс үзэхэд: боловсрол, инженер-технологи, эрүүл мэнд-нийгмийн хамгааллын чиглэлээр суралцагчдын тоо тогтмол өсч, энэ хугацаанд эдгээр салбарын нийт суралцагчдын дүнд эзлэх хувь боловсролд 0.7, инженер-технологид 0.2, эрүүл мэнд-нийгмийн хамгааллын салбарт 2.0 пунктээр дээшилсэн бол харин урлаг, хүмүүнлэгийн салбарын эзлэх хувь 1.1 пунктээр, нийгэм, эдийн засаг, бизнес, удирдлагын салбарын эзлэх хувь 3.9 пунктээр буурсан байгаа нь нааштай хандлага бөгөөд энэ нь “Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний “Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, хөдөө аж ахуйн мэргэжлээр суралцагчдыг дэмжих” гэсэн заалттай нийцэж байна.

Харин “Бусад” салбарын эзлэх хувь (“Үйлчилгээ”-ний бүлгийг хасаад) өмнөх онуудад 0.3 орчим байснаа 2014 онд 2.6 хувь; 2015 онд 1.9, 2016 онд 4.6 хувь хүртлээ өссөн нь МУИС 2014-2015 оны хичээлийн жилээс бакалаврын өдрийн ангийн шинээр элсэгчдийг мэргэжлийн сонголтгүй ерөнхий суурь хөтөлбөрөөр багцалж авч байгаатай холбоотой юм.

2016-2017 оны хичээлийн жилийн суралцагчдын мэргэжлийн чиглэлийг боловсролын зэргээр авч үзвэл: бакалаврын зэргээр суралцагчдын хувьд нийт суралцагчдын мэргэжлийн чиглэлийн хандлагатай ойролцоо байгаа бол магистрантурт суралцагчдын **(38.6)** хувийг бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр суралцагчид эзэлж байгаа нь өмнөх оноос 4.1 пунктээр буурсан байна.

Докторантурт суралцагчдын 9.6 хувийг урлаг, хүмүүнлэг; 8.9 хувийг нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй; 22.1 хувийг бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр



суралцагчид бүрдүүлж байгаа нь өмнөх оноос урлаг, хүмүүнлэгийн салбар 3.2, нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй 6.5 пунктээр тус тус буурсан бол бизнес, удирдлага, эрх зүйн мэргэжлээр суралцагчид 5.7 пунктээр өссөн байна.

Докторантурт байгалийн шинжлэх ухаанаар суралцагчдын хувь **(8.4)**байгаа нь бакалаврт суралцагчдынхаас бараг 2.6 дахин, магистрантурт суралцагчдынхаас 1.6 дахин илүү байна.Өмнөх жил энэ харьцаа бакалаврт 3, магистрантурт 1.4 байсан байна.

Өмнөх онд магистрантур, докторантурт суралцагчдын хувьд инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн эзлэх хувь доогуур **(8.1; 9.7)**бакалаврт эзлэх хувь **(20.7)**-иас 2.1-2.5 дахин бага байсан бол энэ онд бүүр буурч**(7.8; 7.4)**бакалаврт эзлэх хувь **(19.1)**-иас 2.5-2.6 дахин бага байна.

Хөдөө аж ахуй, мал эмнэл зүйн салбарын хувьд өмнөх онд эсрэгээр бакалаврынхаас **(2.2)** магистрантурт 2.5 дахин, докторантурт 4.3 дахин их байсан бол энэ онд мөн адил эсрэгээр бакалаврынхаас **(2.1)** магистрантурт 2.5 дахин, докторантурт 3.9 дахин их байна.

### **2.5. Суралцагчдын орон нутгийн харьяалал**

Нийт суралцагчдын 44.2 хувь буюу 69,513нь Улаанбаатар хотын харьяалалтай, үүнээс бакалавраар суралцагчдын хувьд энэ үзүүлэлт 41.4, магистрантурт суралцагчдад 57.8, докторантурт суралцагчдад 70.1 хувьтай байна.Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад Улаанбаатар хотын харьяалалтай суралцагчдын тоо 2,786-аар буурч, нийт суралцагчдын дүнд эзлэх хувь нь 0.3 пунктээр буурсан байна. Бакалаврын түвшинд суралцаж буй оюутны хувь 0.8 пунктээр буурсан бол магистрантурт суралцагчдын эзлэх хувь 0.6, докторын түвшинд суралцагчдын эзлэх хувь 3.6 пунктээр өссөн нь хөдөө орон нутгаас бакалаврын зэргээр суралцагчид нэмэгдсэнийг харуулж байна.

Нийт суралцагчдын 55.8 хувь буюу 87,625 нь орон нутгийн харьяалалтайгаас хамгийн их нь Архангай 7,192**(8.2%)**,Дархан-Уул 6,224 **(7.1%)**,Хөвсгөл 5,746**(6.6%)**, хамгийн бага нь Говьсүмбэр1,100**(1.3%)**, Сүхбаатар 2,441**(2.8%)**, Дорноговь 2,641**(3.0%)**, Дундговь 2,596**(3.0%)** аймгийн харьяалалтай.

Бүс нутгаар авч үзвэл: Улаанбаатарт хамгийн их буюу 59,513 **(44.2%)**, Хангайн бүсэд 30,778 **(19.6%)**, Төвийн бүсэд 24,695 **(15.5%)**, Баруун бүсэд 22,796**(14.5%)**, Дорнод бүсэд 9,656**(6.1%)** суралцагч тус тус ногдож байна.

Өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ хичээлийн жилд нийт суралцагчдын тоо буурснаас шалтгаалан Улаанбаатар, Дундговь, Дорноговь аймгийн харьяалалтай суралцагчдын тоо багасч, Архангай, Дархан-Уул, Говьсүмбэр аймгийн харьяалалтай суралцагчдын тоо өссөн дүн гарч байна.

### **2.6. Суралцагчдын насны ангилал**

Нийт суралцагчдын 5.8хувь нь 18 хүртэлх насны, 70.8хувь нь 18-24 настай,13.2 хувь нь 25-29 настай,10.2 хувь нь 30 ба түүнээс дээш насны хүмүүс байна.Сүүлийн 6 жилийн судалгаанаас харахад: их, дээд сургууль, коллежид сурч байгаа 18 хүртэлх насны хүүхдийн тоо нэмэгдэж, түүний нийт суралцагчдад эзлэх хувь 2010 онд 5.4 хувь байснаа 2011 онд 6.5 хувь, 2012 онд 9.2 хувь, 2013 онд 11.0 хувь, 2014 онд 10.2 хувь болж өссөн бол 2015онд тус үзүүлэлт ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс бакалаврын ангид шинээр элсэгчдийн тоо буурснаас шалтгаалж 6.9 хувь болж, өмнөх 2 жилийнхээс бараг хоёр дахин буурсан бол 2016 онд 5.8 болж дахин буурсан байна.

Хүснэгт 14. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид (насаар)

Он	Суралцагчдын тоо						
	Бүгд	18 хүртэлх нас	18-24 нас	25-29 нас	30-34 нас	35-39 нас	40 ба түүнээс дээш
2012-2013	175,591	16,134	129,429	18,490	5,523	3,545	2,470
2013-2014	174,045	19,110	122,947	19,430	5,925	3,982	2,651
2014-2015	178,295	18,101	124,990	21,080	6,537	4,391	3,196
2015-2016	162,626	11,142	115,040	20,999	7,277	4,562	3,606
2016-2017	157,138	9,109	111,259	20,773	7,622	4,918	3,457

Өмнөх оныхоос 16 хүртэлх настай суралцагчдын тоо 361-ээр, 16 настай суралцагчдын тоо 656-аар, 17 настай суралцагчдын тоо 1,016-аар тус тус буурсан бол магистрантурт суралцагчдын доод нас 18, докторантурт суралцагчдын доод нас 22 болж, бакалавр, магистрантур, докторантурт суралцагчдын нас залуужиж байгаа нь шинээр элсэгчдийн дотор 8 настайгаас 1 дүгээр ангид элсүүлдэг байх үед 6-7 насандаа бага сургуульд орсон, мөн бага, дунд, ахлах ангидаа анги алгасан дэвшин суралцаж байгаа хүүхдүүд олширч байгаатай холбоотой гэж үзэж байна.

## 2.7. Шинээр элсэгчдийн тоо

Дээд боловсролын сургалтын байгууллагад 2016-2017 оны хичээлийн жилд 41,195 суралцагч шинээр элссэний 27,626 буюу 67.1 хувийг тухайн жилд ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсөж бүрэн дунд боловсрол эзэмшигчид, 3.0 хувийг бусад хэлбэрийн сургуулиас, 17.6 хувийг ажиллагчдаас, 12.3 хувийг ажилгүйчүүдээс элсэгчид бүрдүүлж байна. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад нийт шинээр элсэгчид 12,1721-оор, түүний дотор ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсгөгчдөөс элсэгчдийн тоо 9,798-аар өсчээ. Өнгөрсөн жилтэй харьцуулбал нийт шинээр элсэгчдийн тоонд эзлэх хувь нь ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсгөгчдийн хувьд 6.3 пунктээр, ажилгүйчүүдээс элсэгчдийнх 6.0 пунктээр тус тус дээшилж, эсрэгээр бусад хэлбэрийн сургуулиас элсэгчдийнх 1.3, ажиллагчдаас элсэгчдийнх 10.4 пунктээр тус тус буурсан байна.

Шинээр элсэгчдийг боловсролын зэргээр нь ангилж үзвэл: 35,429 буюу 86.0 хувь нь бакалаврын зэргээр суралцагчид, 5,087 буюу 12.3 хувь нь магистрантурт элсэгчид, 679 буюу 1.6 хувь нь докторантурт элсэгчид байна. Үүнийг өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад бакалаврт элсэгчдийн тоо 11,867-оор, магистрантурт элсэгчдийн тоо 253-аар, докторантурт элсэгчдийн тоо 52-оор тус тус нэмэгдсэн байгаа бол эзлэх хувь нь бакалаврт 4.8 пунктээр дээшилсэн бол, магистрантурт 4.3 пунктээр, докторантурт 0.6 пунктээр тус тус буурчээ.

Хүснэгт 15. Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн тоо (сүүлийн 4 хичээлийн жилээр)

Үзүүлэлт	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Шинээр элсэгчдийн тоо, бүгд	47,182	43,834	29,023	41,195
Бүгдээс: бакалаврт элсэгчид	40,927	37,495	23,562	35,429
Шинээр элсэгчдээс тухайн жилд 12-р ангийг төгсгөгчид	33,273	30,537	17,828	27,626
- Бакалаврт элсэгчдэд 12-р ангийг төгсгөгчдийн эзлэх хувь(%)	81.3	81.4	75.7	78.0
Тухайн жилд ЕБС-ийн 12-р ангийг төгсгөгчдийн тоо, бүгд	35,010	19,735	36,562	
- ЕБС-ийн 12-р ангийг төгсгөгчдийн дунд түүнээс бакалаврт шинээр элсэгчдийн эзлэх хувь (%)	82.4	87.2	90.3	75.6

Сүүлийн 4 жилийн үзүүлэлтүүдэд судалгаа хийж үзэхэд бакалаврын сургалтанд шинээр элсэгчдийн дотор тухайн жилд 12(11) дугаар ангийг төгсгөгчдөөс дээд сургуульд элсэгчдийн хувь 2012-2014 онд тогтвортой, дунджаар 81.0 орчим хувьтай байснаа 2015 онд 75.7 хувь болтлоо буурсан нь 2015 онд ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн тогтолцооны 12 дугаар ангийн анхны төгсөлт болж бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн тоо өмнөх онуудаас бараг 2 дахин багассантай холбоотой байна.

## 2.8. Дотуур байранд сууж байгаа суралцагчдын тоо

2016-2017 оны хичээлийн жилийн эхний байдлаар 12,590 суралцагч дотуур байранд суухаар хүсэлт гаргасны 98.3 хувь буюу 12,374 нь дотуур байраар хангагджээ. Дотуур байранд амьдарч байгаа суралцагчдын 11,198 (90.5%) нь өөрийн сургуулийн, 1,176 (9.5%) нь бусад сургуулийн дотуур байранд сууж байна. Дотуур байранд суугчдын тоо өнгөрсөн хичээлийн жилийнхтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал дотуур байранд суухаар саналаа өгсөн суралцагчдын тоо 850-аар, дотуур байранд суугчдын нийт тоо 1,316-аар өсчээ.

Хүснэгт 16. Дотуур байранд суудаг суралцагчдын тоо (сүүлийн 5 хичээлийн жилээр)

Үзүүлэлт	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Дотуур байранд суухаар саналаа өгсөн, бүгд	16,735	17,192	14,123	11,740	12,590
Дотуур байранд сууж байгаа, бүгд	14,702	14,229	12,748	11,058	12,374
Бүгдээс: эмэгтэй	9,550	9,687	8,887	7,962	8,904
Сургуулийнхаа дотуур байранд сууж байгаа, бүгд	13,173	12,701	11,865	9,774	11,198
Сургуулийнхаа дотуур байранд суугчдын дотуур байранд сууж байгаа нийт суралцагчдад эзлэх хувь (%)	89.6	89.3	93.1	88.4	90.5

Дотуур байранд суухаар саналаа өгсөн суралцагчдын тоо 2012-2013 онд 17,000 орчим, дотуур байранд суугчдын тоо 14,000 гаруйд хэлбэлзэж байсан бол 2014 оноос дээрх хоёр үзүүлэлт ерөнхийдөө буурах хандлагатай байна. Улаанбаатар хотод суралцагчдын бараг тэн хагас хувь нь (47.2% буюу 74,240 суралцагч) орон нутгийн харьяалалтай байгаагаас үзэхэд дотуур байранд суух сонирхол төдийлэн их биш, гол төлөв гадуур хамаатан садныхаараа юмуу хэсэг бүлгээрээ байр түрээслэн суух хандлага давамгайлж байна.

Дотуур байранд үндсэндээ бакалавраар сурч байгаа, өдрийн ангийн оюутнууд сууж байна. Нийт суугчдын 72.0 хувь нь эмэгтэй, 31.7 хувь нь I курс (бэлтгэл ороод), 24.2 хувь нь II курсын оюутнууд, мөн 9,654 буюу 78.0 хувь нь төрийн өмчийн сургуулийн суралцагчид юм. Эдгээр үзүүлэлтийг өнгөрсөн оныхтой харьцуулахад бакалаврын I курсынхаас суугчдын эзлэх хувь 0.5 пунктээр буурсан бол төрийн өмчийн сургуулийн суралцагчид 4.0 пунктээр өссөн байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагуудад 2015 оны эцсийн байдлаар 136.3 мянган м<sup>2</sup> ашигтай талбай бүхий 88 дотуур байр ашиглагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил байна.<sup>10</sup>

<sup>10</sup>Улсын төсвийн хөрөнгөөр Хууль сахиулахын их сургуулийн 850 сонсогчийн дотуур байр шинээр ашиглалтад орсон, 1000 оюутны багтаамж бүхий "Оюутны өргөө" 1, 2 дугаар байр бүрэн хүч чадлаараа үйл ажиллагаагаа эхлэн МУБИС-ийн харьяалалд шилжсэн.

Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагууд үндсэндээ өөрийн эзэмшлийн оюутны дотуур байртай. Харин сургалтын ажиллагаа идэвхтэй эрхэлж байгаа төрийн бус өмчийн 43 сургууль оюутны дотуур байргүй байгаа нь нийт төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагуудын 50.0 гаруй хувийг эзэлж байна. Түүнчлэн гадаадын 5 салбар сургууль бүгд өөрийн эзэмшлийн дотуур байргүй байна.

## 2.9. Суралцагчдын сургалтын төлбөрийн дундаж хэмжээ

2016-2017 оны хичээлийн жилийн байдлаар бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ төрийн өмчийн сургуульд 1,913.0 мянган, төрийн бус өмчийн сургуульд 1,952.2 мянган төгрөг байна. Үүнийг өмнөх хичээлийн жилтэй харьцуулбал: төрийн өмчийн сургуульд сургалтын төлбөр 13.3 хувиар, төрийн бус өмчийн сургуульд 6.0 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 17. Бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ (мянган төгрөг)

Үзүүлэлт	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Төрийн өмчийн сургуульд	921.4	1,149.8	1,490.1	1,688.0	1,913.0
Төрийн бус өмчийн сургуульд	1,093.8	1,292.3	1,595.1	1,842.3	1,952.2
Төрийн ба төрийн бус өмчийн сургуулийн дундаж	1,007.6	1,221.1	1542.6	1765.15	1932.6
Өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувь (%):					
- Төрийн өмчийн сургуульд	12.6	24.8	29.6	13.3	13.3
- Төрийн бус өмчийн сургуульд	21.4	18.1	23.4	15.5	6.0

Сүүлийн 5 жилийн статистикийн мэдээнээс үзэхэд бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ өмчийн хэлбэрээс үл хамааран жил тутам нэмэгдэж ирсэн байгаа бөгөөд 2016 онд 2012 оныхоос төрийн өмчийн сургуульд 2.1, төрийн бус өмчийн сургуульд 1.8 дахин өссөн байна. Сургалтын төлбөрийн хэмжээ төрийн бус өмчийн сургуульд төрийн өмчийнхөөс арай өндөр байна. Сургалтын төлбөрийн хэмжээ боловсролын зэрэг, сургалтын хэлбэрээсээ хамаарч өөр өөр байгаа бөгөөд тухайлбал: магистрантур, докторантурт суралцагчдын сургалтын төлбөр бакалаврын сургалтынхаас харьцангуй өндөр байна.

## 2.10. Суралцагчдын тоог сургуулиудаар бүлэглэсэн байдал

Их, дээд сургууль, коллежийн суралцагчдын тоог бүлэглэн харуулав.

Хүснэгт 18. Суралцагчдын тоог бүлэглэсэн байдал (сургуулийн өмчийн хэлбэрээр)

Суралцагчдын тооны бүлэг	Төрийн өмчийн		Төрийн бус өмчийн		Гадаадын салбар		Бүгд	
	Сургууль	Суралцагч	Сургууль	Суралцагч	Сургууль	Суралцагч	Сургууль	Суралцагч
100 хүртэл суралцагчтай	1		6	251	4	265	11	516
101-200 суралцагчтай	1	101	12	1,742			13	1,843

201-300 суралцагчтай	2	451	12	3,000			<b>14</b>	<b>3,451</b>
301-400 суралцагчтай			7	2,537			<b>7</b>	<b>2,537</b>
401-700 суралцагчтай	1	651	13	6,311			<b>14</b>	<b>6,962</b>
701-1,000 суралцагчтай	2	1,506	8	6,856			<b>10</b>	<b>8,362</b>
1,001-2,000 суралцагчтай	1	1,006	9	12,465			<b>10</b>	<b>13,471</b>
2,001-5,000 суралцагчтай	4	12,709	6	23,025			<b>10</b>	<b>35,734</b>
5,001-10,000 суралцагчтай	1	9,073	1	8,888			<b>2</b>	<b>17,961</b>
10,001-20,000 суралцагчтай	3	44,359					<b>3</b>	<b>44,359</b>
20,001-ээс дээш	1	21,942					<b>1</b>	<b>21,942</b>
<b>Бүгд</b>	<b>17</b>	<b>91,798</b>	<b>74</b>	<b>65,075</b>	<b>4</b>	<b>265</b>	<b>95</b>	<b>157,138</b>

100 хүртэл суралцагчтай 11; 200 хүртэл суралцагчтай 13 сургууль байгаа нь нийт сургуулийн 25.3 хувь, нийт суралцагчдын 1.5 хувь (**тэдгээрт нийт 2,359 суралцагч сурч байгаа**)-ийг эзэлж байна. Дээрх сургуулиудын 2 нь төрийн өмчийн, 18 нь төрийн бус өмчийн, 4 нь гадаадын салбар сургууль юм.

Харин 5,000-10,000 суралцагчтай 2; 10,000-аас дээш суралцагчтай 4 сургууль байгаа нь нийт сургуулийн 6.3 хувь, суралцагчдын 53.6 хувь (**84,262 суралцагч**)-ийг эзэлж байна. Эдгээр 6 сургуулийн 5 нь төрийн өмчийн их сургууль байгаа нь нийт суралцагчдын дийлэнх хэсэг цөөн тооны сургуульд, тэр тусмаа төрийн өмчийн их сургуулиудад төвлөрч байгааг харуулж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад нийт суралцагчдын тоо буурснаас хамаарч 200 хүртэлх суралцагчтай сургуулийн тоо 3-аар, эзлэх хувь нь 1.7 пунктээр буурсан бол 5,000-аас дээш суралцагчтай сургуулийн тоо хэвээр, эзлэх хувь 0.3 пунктээр өсчээ. Эндээс төрийн бус өмчийн сургуулиуд ерөнхийдөө жижгэрч суралцагчдын тоо нь цөөрч байгаагийн дээр 2016 онд шинээр элсэлт муу авсан нь харагдаж байна.

2016-2017 оны хичээлийн жилд төрийн бус өмчийн сургуулиас Их Монгол дээд сургууль, Дизайн урлагийн коллеж, Этүгэн их сургуулийн Дархан-уул аймаг дахь салбар сургууль бакалаврын өдрийн ангидаа шинээр элсэлт авалгүй өнжсөн байна. Түүнчлэн төрийн бус өмчийн 5 сургууль бакалаврын өдрийн ангидаа 20 хүртэл шинээр элсэгчтэй байна.

Хамгийн их суралцагчтай төрийн өмчийн сургууль нь МУИС (**21,942-орон нутаг дахь салбар сургуулиуд ороод**) болж ШУТИС (**19,974-орон нутаг дахь салбар сургуулиуд ороод**)-тай ойролцоо байгаа бол төрийн бус өмчийн сургуулиас Монголын үндэсний их сургууль (**8,888**) хэвээр байна. Түүнчлэн хамгийн цөөн суралцагчтай төрийн өмчийн сургууль нь 2013 онд шинээр байгуулагдсан Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль (**101**), төрийн бус өмчийн сургуулиас мөн онд шинээр байгуулагдсан Гүрэн дээд сургууль (**15**), гадаадын салбар сургуулиас Эрхүүгийн Зам харилцааны улсын их сургуулийн Улаанбаатар хот дахь салбар сургууль (**40**) байна.

### **3. Дээд боловсролын сургалтын байгууллагад гадаадын иргэдээс суралцагчид**

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагад 2016-2017 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр гадаадын 32 орны 1520 иргэн сурч байгаагийн 850 (**55.9%**) нь бакалаврын (**монгол хэлний бэлтгэл ороод**), 497 (**32.7%**) нь магистрын, 173 (**11.4%**) нь докторын сургалтын хөтөлбөрт хамрагдаж байна. Эдгээр суралцагчдын 104 (**6.8%**) нь хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр, 1,261 (**83.0%**) нь хувийн, үлдсэн нь 155 (**10.2%**) бусад зардлаар суралцаж байна. Гадаадын иргэдээс суралцагчдын тоо өмнөх хичээлийн жилийнхээс 70-аар буюу 4.6 хувиар өссөний дотор магистрантурт суралцагчдын тоо 129-өөр, докторантурт суралцагчдын тоо 35-аар тус тус нэмэгдсэн бол бакалавраар суралцагчдын тоо 94-өөр буурсан байна.

Гадаадын суралцагчдын 47.8 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 0.7 пунктээр буурсан байна. Нийт суралцагчдын 73.9 хувь нь (1,123) төрийн өмчийн, 20.5 хувь нь (312) төрийн бус өмчийн, 5.6 хувь нь (85) гадаадын салбар сургуулиудад сурдаг. Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулбал төрийн өмчийн сургуульд суралцагчдын тоо 142 буюу 6.3 пунктээр нэмэгдсэн бол, төрийн бус өмчийнх 61-ээр буюу 5.2 пунктээр, гадаадын салбар сургуулийнх 11-ээр буюу 1.0 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн өмчийн 10, төрийн бус өмчийн 25, гадаадын салбар сургууль 3, нийтдээ дээд боловсролын сургалтын 38 байгууллагад гадаадын оюутан, магистрант, докторант сурч байгаагаас 17 сургууль (44.7 хувь) нь 6-гаас доош суралцагчтай байгаа нь өмнөх жилээс 4-өөр буюу 0.9 пунктээр буурсан байна.

Гадаадаас суралцагч хамгийн олон суралцагчтай сургуульд: төрийн өмчийн сургуулиас Монгол Улсын их сургууль 383, төрийн бус өмчийн сургуулиас Эм Ай Ю дээд сургууль 141, гадаадын салбар сургуулиас ОХУ-ын Дорнод Сибирийн Технологи, удирдлагын их сургуулийн Улаанбаатар хот дахь салбар 52 суралцагчтай байна. Өнгөрсөн онд дээд боловсролын сургалтын 46 байгууллага гадаадын суралцагчтай байсан бол энэ онд 38 болж 8-аар буурсан нь бүгд төрийн бус өмчийн сургуулиуд юм.

БНХАУ-аас 969, ОХУ-аас 182, БНСУ-аас 132 суралцагч байгаа нь нийт гадаадын суралцагчдын 84.4 хувь болж байна. Эдгээр 3 улсаас суралцагчдын хувь өнгөрсөн хичээлийн жилийнхээс 3.0 пунктээр өссөний дээр тооны хувьд БНХАУ-аас суралцагчид 132-оор нэмэгдэж, харин ОХУ-аас суралцагчид 24-өөр, БНСУ-аас суралцагчид 5-аар багасжээ. 1-8 суралцагчтай гадаадын 21 улс байгаа нь өмнөх оноос 4-өөр өссөн байна.

Хүснэгт 19. Дээд боловсролын сургалтын байгууллагад гадаадаас суралцагчдын тоо (сүүлийн 5 хичээлийн жилээр)

Үзүүлэлт	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Гадаадын суралцагчдын улсын тоо	32	30	32	27	32
Гадаадын суралцагчтай сургуулийн тоо	40	40	39	46	38
Гадаадын суралцагчдын тоо, бүгд	1,098	1,130	1,245	1,450	1,520
Бүгдээс: - БНХАУ-аас суралцагчдын тоо	357	449	561	837	969
- ОХУ-аас суралцагчдын тоо	287	250	254	206	182
- БНСУ-аас суралцагчдын тоо	203	203	176	137	132
Бүгдээс: - Магистрантурт суралцагчдын тоо	204	209	258	368	497
- Магистрантурт суралцагчдын хувь (%)	18.6	18.5	20.7	25.4	32.7
Бүгдээс: - Докторантурт суралцагчдын тоо	98	103	114	138	173
- Докторантурт суралцагчдын хувь (%)	8.9	9.1	9.2	9.5	11.4

Сүүлийн 5 жилийн статистик мэдээгээр гадаадаас суралцагчдын тоо өсөж байгаагийн дотор магистрантур, докторантурт суралцагчдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа БНХАУ-аас суралцагчдын тоо сүүлийн 5 жилд 2.7 дахин нэмэгджээ. Харин ОХУ, БНСУ-аас суралцагчдын тоо буурсан үзүүлэлттэй байна.

#### 4. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажиллагчид

**4.1. Нийт ажиллагчдын тоо.** Дээд боловсролын сургалтын байгууллагуудад нийт 12,740 хүн ажиллаж байгаагийн 62.4 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд өнгөрсөн хичээлийн жилийн мөн үетэй харьцуулахад ажиллагчдын тоо 317 хүнээр (-2.5%) цөөрсөнөөс төрийн өмчийн сургуульд 175, төрийн бус өмчийн сургуульд 113, гадаадын салбар сургуульд 29 хүнээр тус тус багасчээ. Нийт ажиллагчдын 8,281 нь (65.0%) төрийн өмчид ажиллаж байгаа нь нийт дүнд эзлэх хувиараа өмнөх оноос 0.2 пунктээр өссөн бол, 4,360 нь (34.2%) төрийн бус өмчид

ажиллаж байгаа нь өнгөрсөн оны түвшиндээ,99 нь**(0.8%)** гадаадын салбар сургуульд ажиллаж байгаа нь 0.2 пунктээр буурсан байна.

**4.2. Үндсэн багшийн тоо.**Нийт ажиллагчдын 6,917нь **(54.3%)**үндсэн багшюм.Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад үндсэн багшийн тоо 204-өөр, түүний дотор төрийн өмчийн сургуульд 134-өөр, төрийн бус өмчийн сургуульд 63-аар, гадаадын салбар сургуульд 7-оор цөөрчээ.Нийт үндсэн багшийн 64.2 хувь нь төрийн өмчийн, 35.5 хувь нь төрийн бус өмчийн, 0.3 хувь нь гадаадын салбар сургуульд багшилж байгаа нь өмнөх хичээлийн жилээс төрийн өмчийн сургуульд ажиллаж байгаа багшийн тоо 0.1 пунктээр, гадаадын салбар сургуульд ажиллаж байгаа багшийн тоо 0.1 пунктээр тус тус буурсан бол төрийн бус өмчийн сургуульд ажиллаж байгаа багшийн тоо 0.2 пунктээр өссөн байна.Сургуулийн тоо, суралцагчдын тоо багассан нь үндсэн багшийн тоо буурахад нөлөөлсөн байх талтай.

Хүснэгт 20. Их, дээд сургуулийн үндсэн багш

	<b>Их, дээд сургуулийн үндсэн багш</b>			
	Нийт	Төрийн	Хувийн	Гадаадын салбар
<b>2012-2013</b>	<b>7,331</b>	4,695	2,594	42
<b>2013-2014</b>	<b>7,385</b>	4,675	2,664	46
<b>2014-2015</b>	<b>7,528</b>	4,779	2,711	38
<b>2015-2016</b>	<b>7,121</b>	4,578	2,517	26
<b>2016-2017</b>	<b>6,917</b>	4,444	2,454	19

Нийт үндсэн багшийн 2,034нь**(29.4%)** докторын зэрэгтэй, 4,560 нь**(65.9%)** магистрын зэрэгтэй байгаа нь докторын зэрэгтэй үндсэн багшийн тоо 107 буюу 3.4 пунктээр өссөн бол магистрын зэрэгтэй үндсэн багшийн тоо 230-аар буурсан хэдий ч нийт дүнд эзлэх хувь 2.8 пунктээр дээшилжээ.Цагийн багш 1,434 байгаа нь өмнөх оноос 106-аар өссөн байна.

Нийт үндсэн багшийн 7.3 хувь нь дадлагажигч<sup>11</sup> багш, 41.6 хувь нь багш, 29.5 хувь нь ахлах багш, 12.0 хувь нь дэд профессор, 9.7 хувь нь профессор багш байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад дадлагажигч багшийн эзлэх хувь 0.9, профессор багшийн эзлэх хувь 0.9 пунктээр тус тус багасч, багшийн эзлэх хувь 0.1, ахлах багш 1.7, дэд профессор багшийн эзлэх хувь 0.1 пунктээр тус тус өсчээ.

Хүснэгт 21. Багш нарын нас (насны ангилалаар)

	30 хүртэл	30-50	51-55	56-59	60 ба түүнээс дээш
<b>2012-2013</b>	2,097	3,632	765	340	497
<b>2013-2014</b>	2,025	3,812	677	317	554
<b>2014-2015</b>	1,897	4,029	664	347	591
<b>2015-2016</b>	1,508	4,043	660	372	538
<b>2016-2017</b>	1,363	3,943	728	363	520

Насны хувьд нийт үндсэн багшийн 19.7 хувь нь 30 хүртэлх насны залуучууд, 15.3хувь нь 55-аас дээш насны ахмад багш нар бөгөөд тэдгээрээс 486 нь тэтгэврээ тогтоолгоод ажиллаж байна. Улсад ажилласан жилээр нь ангилж үзвэл: 19.7 хувь нь 1-5 жил, 15.0 хувь нь 25-аас дээш жил ажилласан ажлын дадлага туршлагатай хүмүүс байна.Өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад 30 хүртэлх насны болон 1-5 жил ажилласан хүний эзлэх хувь 1.5 ба 0.8 пунктээр тус тус багасч, 55-аас дээш насны хүний эзлэх хувь 2.5 пунктээр нэмэгджээ.

<sup>11</sup>Дээд боловсролын тухай хуулийн 13.3-д “Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаал нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш байна” гэж заасан.

## 5. Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсгөгчид

**5.1. Төгсгөгчдийн тоо, боловсролын зэрэг.** Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо жилээс жилд өсөж байснаас төгсгөгчдийн тоо өмнөх жилүүдэд мөн адил өсөж байсан бол сүүлийн жилийн байдлаар энэ хандлага өөрчлөгдөж байна. 2011-2012 оны хичээлийн жилд 37,749 суралцагч, 2012-2013 оны хичээлийн жилд 37,243 суралцагч, 2013-2014 оны хичээлийн жилд 33,850 суралцагч, 2014-2015 оны хичээлийн жилд төгссөн бол 35,181, 2015-2016 оны хичээлийн жилд 35,889 суралцагч сургуулиа төгссөн нь өмнөх хичээлийн жилийнхээс 708-ээр буюу 2.0 хувиар их, 2011-2012 оны хичээлийн жилийнхээс 1,860-аар буюу 4.9 хувиар бага байна.

Нийт төгсгөгчдийн 19,896 буюу 55.4 хувийг төрийн өмчийн, 15,993 буюу 44.6 хувийг төрийн бус өмчийн сургуулийн суралцагчид эзэлж байгаа нь өнгөрсөн хичээлийн жилийнхтэй харьцуулахад тооны хувьд төрийн өмчийн сургуулийн төгсгөгчид 938-аар буюу 1.5 пунктээр нэмэгдсэн бол төрийн бус өмчийн сургуулийн хувьд 230 буюу 1.5 пунктээр буурсан байна.

Хүснэгт 22. Төгсгөгчид(боловсролын зэргээр)

	Төгсгөгчид	Дипломын дээд	Бакалавр	Магистр	Доктор
2011-2012	37,749	918	33,106	3,626	99
2012-2013	37,243	1,181	32,234	3,697	131
2013-2014	33,850	259	29,477	3,996	118
2014-2015	35,181	93	29,728	5,254	106
2015-2016	35,889	231	30,663	4,859	136

Нийт төгсгөгчдийн 231 нь дипломын дээд (0.6%), 30,663 нь бакалаврын (85.4%), 4,859 нь магистрын (13.5%), 136 нь докторын (0.4%) зэргээр төгсжээ. Төгсгөгчдийн тооны өсөлт, бууралтыг өнгөрсөн хичээлийн жилийнхтэй харьцуулж боловсролын зэргээр авч үзвэл: дипломын дээд (+138), бакалавр (+935), доктор (+30)-аар нэмэгдсэн бол, магистр (-395) буурсан байна.

**5.2. Төгсгөгчдийн хүйсийн харьцаа.** Нийт төгсгөгчдийн 60.9 хувийг эмэгтэйчүүд, 39.1 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж, хүйсийн ялгааны индекс 1.56 байна. Энэ нь өөрөөр хэлбэл 100 эрэгтэй төгсгөгчид 164 эмэгтэй төгсөгч ногдож байна гэсэн үг. Өмнөх оны төгсгөгчдөөс эмэгтэйчүүд 1.2 пунктээр буурсан бол, эрэгтэйчүүд 1.2 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Дээд боловсролын бүх зэргээр төгсгөгчдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж байна.

Хүснэгт 23. Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсгөгчид (хүйс, боловсролын зэргээр)

	бакалавр	магистр	доктор
эрэгтэй	39.6 %	36.1 %	36.0 %
эмэгтэй	60.4 %	63.9 %	64.0 %

Төгсгөгчдийн хүйсийн харьцаа зарим мэргэжлийн чиглэлүүдээр эрс ялгаатай байна. Жишээ нь: анагаах ухааны салбарын төгсгөгчдийн 83.5%, боловсролын салбарын төгсгөгчдийн 81.8%, нийгмийн халамж, мэдээлэл-сэтгүүл зүй, биологи, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр суралцаж төгсгөгчдийн 79.9-82.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол компьютер, тээвэр (төмөр зам), барилга-архитектур, бүх төрлийн инженерийн чиглэлээр төгсгөгчдийн 71.7-86.2 хувь, цэрэг, цагдаа, аюулгүй байдлын салбарын төгсгөгчдийн 90.4 орчим хувь нь эрэгтэйчүүд байна.



**5.3. Төгсгөгчдийн мэргэжлийн чиглэл.** Нийт төгсгөгчдийн 15.3% нь боловсрол, 6.0% нь урлаг ба хүмүүнлэг, 38.3% нь нийгэм, эдийн засаг, мэдээлэл-сэтгүүл зүй, бизнес, удирдлага, эрх зүй, 4.8% нь байгалийн шинжлэх ухаан, 15.4% нь инженер, технологи, барилга-архитектур, 2.7% нь хөдөө аж ахуй, 10.7% нь эрүүл мэнд, нийгмийн халамж, 5.2% нь үйлчилгээний, 1.5% нь бусад салбарт хамаарч байна. Үүнийг өмнөх хоёр хичээлийн жилтэй харьцуулбал: инженер, технологи, барилга-архитектурын салбарын эзлэх хувь 12.7-15.4 хүртэл өсөж, бусад салбарын хувь ойролцоо түвшинд байна. Гэхдээ урлаг ба хүмүүнлэг, нийгэм, эдийн засаг, мэдээлэл-сэтгүүл зүй, бизнес, удирдлага, эрх зүйн салбараар төгсгөгчдийн нийт дүнд эзлэх хувь 44.3-45.4 буюу зонхилох хэсэг нь хэвээр байна.

**5.4. Төгсгөгчдийн ажил эрхлэлтийн байдал.** 2015-2016 оны хичээлийн жилийн нийт төгсгөгчдийн 30.9 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон гэсэн статистик мэдээ гарлаа. Энэ үзүүлэлт өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад 1.9 пунктээр буурчээ. Докторантур төгсгөгчид бараг бүхэлдээ (98.5%), магистрантур төгсгөгчдийн 86.7 хувь нь ажлын байртай хүмүүс байгаа бол бакалаврын зэргээр төгсгөгчдийн ажил эрхлэлтийн байдал 21.8 орчим хувьтай байгаа нь нэгдүгээрт, зарим сургуулиуд төгсгөгчдийн ажил эрхлэлтийн мэдээгээ бүрэн гаргаж чадахгүй байгаа, хоёрдугаарт, төгсгөгчид төгссөн үедээ тэр бүр ажлын байртай болж амжихгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

## **6. Дээд боловсролын магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагууд**

**6.1. Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо.** 2016 оны эцсийн байдлаар дээд боловсролын сургалтын 74<sup>12</sup> байгууллагын магадлан итгэмжлэл нь хүчинтэй байгаагаас 69<sup>13</sup> нь их, дээд сургууль байна. Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо 2009 оны эцэст 86, 2010 онд 68, 2011 онд 67, 2012 онд 70, 2013 онд 63<sup>14</sup>, 2014 онд 65, 2015 онд 67 болсон байна.

Төрийн өмчийн сургуулиудаас Үндэсний тагнуулын академи, Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль магадлан итгэмжлэлд ороогүй байгаа бол төрийн бус өмчийн 18 их сургуулийн 1 (Монгол дахь Америкийн их сургууль) нь, 54 дээд сургуулийн 18 нь, 2 коллежийн 1 (Дизайн урлагийн коллеж) нь, гадаадын 4 салбар сургууль бүгд магадлан итгэмжлэгдээгүй байна. Түүнчлэн Утга зохиол, нийгмийн ажилтны дээд сургуулийн магадлан итгэмжлэгдсэн хугацаа 2012 оны сүүлээр, Жонон дээд сургууль, Энх орчлон дээд сургуулийн магадлан итгэмжлэлийн хүчинтэй байх хугацаа 2013 онд тус тус дуусгавар болж, эдгээр сургуулиуд одоогоор дахин магадлан итгэмжлэлд ороогүй байна. 2017 онд 19 сургуулийн магадлан итгэмжлэлийн хугацаа дуусахаар байна.

**6.2. Магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцагчдын тоо.** Дээрх магадлан итгэмжлэгдсэн 69 сургуульд 152,786 суралцагч сурч байгаа нь нийт суралцагчдын 97.2 хувийг эзэлж байгаа өмнөх оноос 2.1 пунктээр өссөн байна. Эдгээрээс 91,697 (**60.0%**) нь төрийн өмчийн, 61,089 (**40.0%**) нь төрийн бус өмчийн сургуульд сурч байгаа нь нийт дүнд эзлэх хувиараа өнгөрсөн оныхоос төрийн өмчийн сургуулийн сурагчдын эзлэх хувь 0.8 пунктээр буурсан бол, төрийн бус өмчийн сургуулийн хүүхдийн эзлэх хувь эсрэгээрээ 0.8 пунктээр өссөн байна. Элсэгчдийн тоо буурснаас хамаарч магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцагчдын тоо өнгөрсөн оныхоос 1.4 мянгаар буюу 0.9 хувиар багасчээ.

-----000-----

<sup>12</sup>Энэ тоонд мэргэжлийн 5 сургууль орсон. Үүнд: Дархан-уул аймаг дахь Уул уурхайн эрчим хүчний политехник коллеж, Үйлдвэрлэл урлалын политехник коллеж, Монгол-Солонгосын политехник коллеж, Завхан аймаг дахь политехник коллеж, Баянхонгор аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв

<sup>13</sup>Мэргэжлийн 5 сургуулийг хассан тоо.

<sup>14</sup>Өмнө нь бие даан магадлан итгэмжлэгдсэн байсан төрийн өмчийн харьяа сургуулиуд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 15 дугаар тогтоолоор төрийн өмчийн их сургуулиудын салбар болон бүрэлдэхүүний сургууль болж өөрчлөгдсөнөөс магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо буурсан байдаг.